



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 434

Улаанбаатар хот

“Монголын хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хяналтын багц эзэмшигчээс Компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтыг хэрэгжүүлэх, хувьцааг худалдан авахаар гаргасан саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 57.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ыг 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монголын хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт гаргасан 50,000 ширхэг хувьцааны 89,77 хувь буюу 44,886 ширхэг хувьцааг эзэмшигч болох “Монгол 999 үндэсний нэгдэл” хаалттай ХК /Т.Наранбулаг/-аас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 10,23 хувь буюу 5,114 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 3522 /гурван мянга таван зуун хорин хоёр/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. “Монголын хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцаа эзэмшигч “Монгол 999 үндэсний нэгдэл” хаалттай ХК /Т.Наранбулаг/-аас бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг хувьцаа эзэмшигч “Монгол 999 үндэсний нэгдэл” хаалттай ХК /Т.Наранбулаг/-т үүрэг болгосугай.

1/ Компанийн тухай хуулийн 57.3-т заасны дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, хувьцааг худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт багтаан хувьцааг худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг тус Хороонд ирүүлэх;

000473

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийг цаашид компанийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН